



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№176 /386/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.10.03



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЗААХ АРГА ЗҮЙН ЦУГЛАРАЛТ ЭХЭЛЛЭЭ



Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний Заах арга зүйн цугларалт “Удирдах бүрэлдэхүүний манлайлал-цэргийн сургалт бэлтгэлд нөлөөлөх нь” сэдвээр энэ сарын 3-5-ны өдрүүдэд зохион байгуулагдах юм.

Энэ удаагийн цугларалтаар Зэвсэгт хүчний бэлэн байдлыг хангахад удирдах бүрэлдэхүүний манлайлах ур чадвар цэргийн сургалт бэлтгэлд нөлөөлөх арга

замыг тодорхойлж, тэдний манлайллыг нэмэгдүүлэх, 2022-2023 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн зорилго, зорилт, зохион байгуулж явуулах онцлог, туршлага сургамж, дүгнэлт, цаашид хийж хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэний дээр удирдах бүрэлдэхүүний үзэл бодол, санал хүсэлтийг сонсож тулгамдаж буй асуудлыг хамтын хүчээр

шийдвэрлэх зорилготой юм.

ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба цугларалтыг нээж хэлсэн үгэндээ дэлхийн улс орнуудын цэрэг, улс төрийн байдал тогтворгүй байгаа энэ үед тус цугларалтыг зохион байгуулж байгааг онцлоод Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын үүрэг гүйцэтгэх бэлэн байдал, бэлтгэлжилтийн түвшнийг дээшлүүлэхэд

бүх шатны дарга, захирагч нарын ажлын арга барил, манлайлал, сургалтын арга технологийг өөрчлөх зайлшгүй шаардлагатай байгааг анхааруулж үүрэг чиглэл өглөө.

Үргэлжлүүлэн Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, ЗХЖШ-ын орлогч дарга, ЦТГ-ын дарга хошууч генерал А.Ганбат нар тодорхой сэдвүүдээр хэлэлцүүлэг өрнүүлэв.



“МОНГОЛ УЛСЫН ЦЭРГИЙН НИЙТЛЭГ ДҮРМҮҮД”-ИЙГ ГАРДУУЛЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зарлигаар шинэчлэн батлагдсан “Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд”-ийг Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдлагад гардуулах ёслолын ажиллагаа боллоо.

Уг ёслолын ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Г.Нямбаатар, Монгол Улсын ҮАБЗ-ийн Нарийн бичгийн дарга Ж.Энхбаяр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Ц.Тогоо, Монгол Улсын ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, Батлан хамгаалах яам, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдлага, Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний заах аргын цугларалтад оролцож буй бие бүрэлдэхүүн оролцлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх “Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд”-ийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Г.Нямбаатар нарт гардуулан өгсний дараа бие бүрэлдэхүүнд хандаж үг хэлсэн юм.

Тэрээр “Улс орны аюулгүй байдлын гадаад, дотоод орчинд эрс өөрчлөлт гарч, эх орон, ард түмнийхээ аюулгүй байдлыг хангах үйлсэд өмнөхөөсөө илүү анхаарал хандуулах шаардлага тулгарсан нэн хариуцлагатай цаг үед Та бүхэнтэй уулзаж байна. Хүн төрөлхтөн, дэлхий нийтээрээ цар тахал, геополитикийн эдрээтэй цаг үеийг хамтдаа туулж байна. Дэлхий нийтийг хамарсан цар тахал, олон улс, бүс нутагт үүсээд буй цэрэг-улс төрийн хурцадмал байдлаас үүдэлтэй аюулгүй байдлын тогтворгүй орчин, эдийн засгийн хямрал бий болсон нь урт хугацаанд үргэлжлэх төлөвтэй байгаа төдийгүй манай улсад ч мөн нөлөөлж байна.

Шинэчлэн баталсан “Цэргийн нийтлэг дүрмүүд” нь Төрийн албаны тухай хууль болон батлан хамгаалах багц хуулиудын үзэл санаатай нийцэж байгаа юм. Мөн нийгмийн хөгжил, шинэ үеийн үзэл бодол, хүмүүжил, төлөвшлийн хандлага болон монгол цэргийн түүхэн уламжлалд нийцсэн өөрчлөлтүүдийг тусгаж, цэргийн алба, сургалт бэлтгэлийг мэргэжлийн армийн жишигт нийцүүлэхэд чиглэсэн эрх зүйн чухал баримт бичиг боллоо. Та бүхэн “Цэргийн нийтлэг дүрмүүд”-ийг бие бүрэлдэхүүнээрээ сайтар судлуулан чанд мөрдүүлж, цэргийн алба, үйл ажиллагаагаа дүрмийн дагуу явуулахад тодорхой ахиц гаргана гэдэгт итгэж байна” гэсэн юм.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)